

2 САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ НОГООН УГААЛТ

П.Байгалмаа, Б.Даваамаа, Б.Гал, Б.Сайнбилэг

ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд дэлхийн санхүүгийн салбарт тогтвортой хөгжил, байгаль орчныг хамгаалах чиг хандлага эрчимтэй өсөж, “ногоон хөрөнгө оруулалт”, “тогтвортой санхүүжилт”, “ESG тайлагнал” зэрэг ойлголтууд өргөн хэрэглэгдэх болсон. Үүнтэй зэрэгцэн зарим байгууллага “ногоон угаалт” буюу байгальд ээлтэй мэт худал, төөрөгдүүлсэн мэдээлэл түгээж, нэр хүнд болон ашиг орлогоо нэмэгдүүлэх үзэгдэл түгээмэл байна.

Энэхүү судалгааны зорилго нь санхүүгийн салбар дахь ногоон угаалтын мөн чанар, илрэх хэлбэр, шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, олон улсын стандарт болон улс орнуудын зохицуулалтын жишгийг судалж, Монгол Улсад авч хэрэгжүүлбэл зохих зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны үр дүнд ногоон угаалт нь санхүүгийн зах зээлийн итгэлцэл, ил тод байдлыг алдагдуулж, тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд сөрөг нөлөөтэйг тогтоов.

Түлхүүр үгс: Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG), ногоон угаалт, санхүүгийн салбар

JEL ангилал: G18, Q56, M14

¹ СЗХ, ЗЗСХГ, Ахлах референт, baigalmaa@frc.mn

² СЗХ, ЗЗСХГ, Ахлах мэргэжилтэн, davaamaa@frc.mn

³ СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, gal@frc.mn

⁴ СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, sainbileg@frc.mn

АГУУЛГА

I.	УДИРТГАЛ	54
II.	НОГООН УГААЛТЫН СУУРЬ ОЙЛГОЛТ	55
	2.1 Ногоон угаалтын тодорхойлолт	55
	2.2 Ногоон угаалтын шалтгаан ба ангилал	56
	2.3 Ногоон угаалтаас үүсэх эрсдэл, түүнээс сэргийлэх нь	56
III.	САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ НОГООН УГААЛТ	61
	3.1 Санхүүгийн салбарын оролцоо ба ногоон угаалтын өсөлт	61
	3.2 Ногоон угаалтын илрэх байдал	64
	3.3 Дэлхийг донсолгосон томоохон кейсүүд	65
	3.3.1 DWS	65
	3.3.2 Goldman Sachs	66
	3.3.3 BNY Mellon	67
IV.	НОГООН УГААЛТЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ БА УЛС ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ	68
	4.1 Олон улсын стандарт	68
	4.1.1 Global reporting initiative (GRI)	68
	4.1.2 Sustainability Accounting Standards Board (SASB)	69
	4.1.3 ISO 14030 стандарт	70
	4.1.4 Стандартуудын харьцуулалт ба Монгол Улсад ашиглах шийдэл	72
	4.2 Улс орнуудын зохицуулалт	73
	4.2.1 Европын холбоо (ЕХ)	73
	4.2.2 Америкийн Нэгдсэн Улс (АНУ)	76
	4.2.3 Сингапур улс	78
	4.3.4 Монгол Улс	80
	4.3.5 Улс орнуудын зохицуулалтын харьцуулалтын шинжилгээ	83

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	84
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	86
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1. ISO 14030 стандарт	71
Хүснэгт 2. Стандартуудын зорилго	72
Хүснэгт 3. Европын холбооноос баталсан гол баримт бичгүүд	74
Хүснэгт 4. Америкийн Нэгдсэн Улсын баталсан гол баримт бичгүүд	76
Хүснэгт 5. Сингапур улсад мөрдөгдөж буй гол баримт бичгүүд	78
Хүснэгт 6. СЗХ-ны хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилт	82
Зураг 1. Тогтвортой өрийн хэрэгсэл	63
Зураг 2. Санхүүгийн салбар дахь ногоон угаалтын тохиолдол	63

I. УДИРТГАЛ

Өнөө үед эдийн засаг, нийгмийн хөгжил нь байгаль орчны тогтвортой байдлаас шууд хамаарах болсон. Тиймээс дэлхий даяар уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн хомсдол, байгаль орчны доройтол зэрэг асуудлууд улам хурцаар тавигдаж байна. Үүнтэй уялдан “ногоон хөгжил”, “тогтвортой санхүүжилт”, “байгаль орчин, нийгэм, засаглалын зарчим” (ESG) зэрэг ойлголтууд дэлхийн санхүүгийн системд гүнзгий нэвтэрч, бодлого, шийдвэр гаргалтын салшгүй хэсэг боллоо.

Энэхүү чиг хандлага өргөжихийн хэрээр зарим байгууллагууд байгаль орчинд ээлтэй мэтээр худал, төөрөгдүүлсэн мэдээлэл түгээж, өөрийн нэр хүнд, ашиг орлогоо нэмэгдүүлэх “ногоон угаалт” (greenwashing) гэх үзэгдэл өргөн дэлгэр болж байна.

Санхүүгийн салбар дахь ногоон угаалт нь бусад салбараас илүү төвөгтэй илрэх хандлагатай бөгөөд “ногоон зээл”, “ногоон бонд”, “тогтвортой хөрөнгө оруулалт” гэх мэт нэрийн дор бодит бус мэдээлэл түгээгддэг.

Үүний үр дүнд санхүүгийн байгууллагуудад итгэх хөрөнгө оруулагчдын итгэлцэл буурч, хөрөнгө оруулах шийдвэр гажуудан улмаар эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсдэг.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь санхүүгийн салбар дахь ногоон угаалтын

суурь ойлголт, шалтгаан, хэлбэр, эрсдэлийг тодорхойлж, олон улсын стандартууд (GRI, SASB, ISO 14030) болон улс орнуудын (Европын холбоо, АНУ, Сингапур) зохицуулалтын жишгийг харьцуулан судлах замаар Монгол Улсад ногоон угаалтаас урьдчилан сэргийлэх, хязгаарлах, таслан зогсоох арга хэмжээ авах зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгаанд үндэслэн ил тод, баталгаатай ESG тайлагнал, хөндлөнгийн аудитын тогтолцоо, нэгдсэн стандартуудыг хэрэгжүүлэх нь ногоон угаалтаас үүдэх эрсдэлийг бууруулах хамгийн үр нөлөөтэй хэрэгсэл гэж үзэж байна.

Уг судалгаанд баримт бичгийн шинжилгээ, олон улсын харьцуулалт, кейс судалгаа болон чанарын дүн шинжилгээний аргыг ашигласан.

Судалгаа нь санхүүгийн салбарын хүрээнд хийгдсэн болно.

Судалгааны үр дүн нь Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого, тогтвортой санхүүжилтийн стратегийг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодит ахиц гаргах, санхүүгийн ил тод, хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

II. НОГООН УГААЛТЫН СУУРЬ ОЙЛГОЛТ

Энэхүү бүлэгт ногоон угаалт (*greenwashing*)–ын үүсэл, утга агуулга, олон улсын тодорхойлолт, илрэх хүчин зүйл ба хэлбэр,

түүний улмаас үүсэх эрсдэл, түүнээс сэргийлэх үндсэн зарчмыг авч үзнэ.

2.1. НОГООН УГААЛТЫН ТОДОРХОЙЛОЛТ

“Ногоон угаалт” хэмээх нэр томъёог анх байгаль орчны идэвхтэн Жей Вестервелд (1986) ашигласан. Тэрээр Фижи аралд аялж байхдаа нэгэн амралтын газрын үүдэнд “байгаль орчныг хамгаалахын тулд алчуураа дахин ашиглана уу” гэсэн уриалгатай таарчээ.

Жей Вестервелд нийтлэлдээ уг уриалга бол анх буюу өнгөц харахад зочид буудлыг экологийн хариуцлагатай, ногоон бодлого баримталдаг гэж эерэг ойлголтыг төрүүлэх боловч бодит байдал дээр алчуур угаах хэрэглээний зардал (цахилгаан эрчим хүч, ариутгалын бодис, ажлын хөлс)–аа хэмнэхийн тулд байгаль орчноо дээдлэх үйлчлүүлэгчдийн сэтгэл зүйн мэдрэмжийг онилсон маркетингийн арга болохыг мэдэж шүүмжилсэн⁵–ээр гарч ирсэн.

Өнөөдөр “Ногоон угаалт” гэх нэр томъёог өргөн хэрэглэж байгаа ч эрх бүхий байгууллагаас албан ёсоор тодорхойлоогүй ч дараах байдлаар илэрхийлжээ.

Тухайлбал:

- Олон улсын үнэт цаасны комисс (2021) «Хөрөнгийн удирдлагын тайлан»–д ногоон угаалтыг «тогтвортой байдлын практик эсвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний тогтвортой байдалтай холбоотой шинж чанаруудыг буруугаар тайлбарлах явдал»;
- Их Британийн Хуулийн нийгэмлэг “байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг бодит бус харуулсан үйлдэл”;
- Европын холбоонд Европын санхүүгийн хяналтын байгууллагууд ногоон угаалтыг “тогтвортой байдалтай холбоотой мэдэгдэл, үйл ажиллагаа, харилцаа холбоо нь аж ахуйн нэгж, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үндсэн тогтвортой байдлын дүр төрхийг тодорхой бөгөөд шударгаар тусгаагүй үйлдэл”.

Санхүүгийн салбарын хүрээнд ногоон угаалт гэдэг нь ерөнхийдөө компанийн санхүүгийн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын стратеги нь байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж буй шинж чанар, цар хүрээний талаарх

⁵ Gellweiler, S.; Higson, P. The SAGE International Encyclopedia of Travel and Tourism; SAGE Publications, Inc.: Thousand Oaks, CA, USA, 2017; Volumes 1–4, pp. 544–546.

худал, хуурмаг, төөрөгдүүлсэн мэдэгдэл, төлөвлөлтийг хэлнэ.

Энэ нь тухайн компани байгаль орчинд цэвэр эерэг эсхүл төвийг сахисан нөлөө үзүүлэхийг санал болгосон тохиолдолд

тэдний бизнесийн загвар, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нь байгаль орчинд хор хөнөөл учруулж болзошгүй тохиолдолд илэрдэг гэсэн үг юм.

2.2. НОГООН УГААЛТЫН ШАЛТГААН БА АНГИЛАЛ

Ногоон угаалт нь нэг талаас дотоод, нөгөө талаас гадаад хүчин зүйлээс үүдэлтэй үүсдэг гэж үзэж болно.

1. Гадаад хүчин зүйлс:

- Эрэлт нэмэгдэх – “ногоон” буюу тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт өсөх. Тухайлбал: 2022 онд First Insight судалгаагаар Z үеийнхний 73 хувь, миллениалын 68 хувь нь тогтвортой бүтээгдэхүүнд илүү мөнгө төлөхөд бэлэн гэсэн нь эрэлт бий болгосон.
- Хэтрүүлсэн сурталчилгаа – бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтвортой байдлын тодорхойлолттой холбож, бодитой бус байдлаа нуун сурталчлах.
- Мэдээллийн зөрүү – байгууллагын түвшинд тогтвортой байдлын үнэлгээ, тайлангийн найдвартай байдлыг хангахтай холбоотой тайлагнах.
- Гуравдагч талын дарамт – ТББ-ууд болон олон нийтийн хяналт, зохицуулалтын хэрэгжилтийг хангах шахалт.

2. Үйл ажиллагааны буюу дотоод хүчин зүйлс:

- Зохицуулалтын цоорхой, зөрчил – хууль эрх зүйн шаардлагууд тодорхой бус эсхүл уялдаагүй.
- Засаглалын сул тал – удирдлага, хүний нөөцийн чадвар дутмаг.
- Хязгаарлагдмал нөөц – Байгууллагын дотоод хяналт, дагаж мөрдөх тогтолцоо сул, шаардлагатай хөрөнгө болон мэдлэг дутмаг.
- Мэдээллийн чанар – Санхүү, хөрөнгө оруулалт, тогтвортой байдлын мэдээлэл бүрэн бус, найдвартай биш байх.
- Шошго ба мэдээллийн буруу хэрэглээ – Стандарт, тэмдэглэгээний шаардлагыг буруу ойлгох, хөрөнгө оруулагчдын мэдлэг дутмаг байдлаас болж мэдээллийг буруу ашиглах.

Ногоон угаалт үйлдэгдэх тохиолдлыг “Террачойс”⁶ байгаль орчны судалгааны компани (2007) гүйцэтгэсэн судалгаандаа “Ногоон угаалтын 7 нүгэл» (*The Seven Sins of Greenwashing*) гэж ангилсан. Үүнд:

⁶ TerraChoice Environmental Marketing Inc. The Seven Sins of Greenwashing: A Study of Environmental Claims in Consumer Markets. 2007 (https://sustainability.usask.ca/documents/Six_Sins_of_Greenwashing_nov2007.pdf) <https://www.greenbusinessbenchmark.com/archive/7-sins-of-greenwashing>

Нүгэл №1: Далд худалдааны нүгэл (*The Sin of Hidden Trade-Off*): Энэ нь бүтээгдэхүүний зөвхөн нэг хэсэг нь “ногоон” гэж онцолж, харин үйлдвэрлэлийн явцад гардаг бусад сөрөг нөлөөллийг орхигдуулахыг хэлнэ. Жишээ нь, дахин боловсруулсан цаасаар хийсэн бүтээгдэхүүнийг сурталчлахдаа түүнийг үйлдвэрлэхэд их хэмжээний энерги, ус зарцуулсныг нуух.

Нүгэл №2: Нотлогдохгүй нүгэл (*The Sin of No Proof*): Энэ нь ямар нэг баримт, нотолгоогүйгээр “ногоон” гэх мэдэгдэл хийх явдал юм.

Нүгэл №3: Тодорхой бус байдлын нүгэл (*The Sin of Vagueness*): “Байгальд ээлтэй”, “ногоон”, “эко” гэх мэт утга нь тодорхой бус, хоёрдмол утгатай үгсээр сурталчилгаа хийх. Эдгээр үгс нь хуулиар тогтоосон тодорхой стандартгүй тул хэрэглэгчдийг төөрөгдүүлэхэд ашиглагддаг.

Нүгэл №4: Худал мэдээлэл (*The Sin of Fibbing*): Энэ нь худал, хуурамч мэдэгдэл хийх эсхүл огт байхгүй байж сертификат, стандарттай мэтээр харагдуулахыг хэлнэ. Жишээ нь, стандартад нийцсэн “Органик” гэх хуурамч шошго ашиглах.

Нүгэл №5: Үл хамаарах нүгэл (*The Sin of Irrelevance*): Байгаль орчинд хамааралгүй эсхүл хуулиар зайлшгүй шаардагддаг шинж чанарыг сурталчилгаандаа онцлох. Жишээ нь, бүтээгдэхүүнээ CFC (хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодис) агуулаагүй гэж сурталчлах.

Нүгэл №6: Хоёр муугийн бага нүгэл (*The Sin of Lesser of Two Evils*): Бага хортойг нь онцлох. Хэдийгээр тухайн бүтээгдэхүүн нь «ногоон» мэт боловч, үнэндээ байгаль орчинд сөрөг нөлөөтэй байх тохиолдол. Жишээ нь, «эко» тамхи эсхүл «ногоон» тээврийн хэрэгсэл (бензинээр ажилладаг) гэж сурталчлах.

Нүгэл №7: Хуурамч шошго шүтэх нүгэл (*The Sin of Worshipping False Labels*) Энэ нь хэрэглэгчдийг төөрөгдүүлэхийн тулд хуурамч гэрчилгээ эсхүл шошго бий болгох. Ингэснээр хэрэглэгчдийг ямар нэгэн бүтээгдэхүүн, үйлчилгээндээ хууль ёсны зөвшөөрөл авсан гэж итгүүлэх. Энэхүү хуурамч гэрчилгээтэй холбоотой асуудал нь далайн салбарт нэлээд байдаг. 2001 онд Олон улсын далайн байгууллага (ИМО) гэрчилгээг хуурамчаар үйлдсэн 12,635 тохиолдол илрүүлжээ.

Харин Planet Tracker⁷ судалгааны байгууллага (2023)-аас ногоон угаалтыг илрэх шинж чанараас нь хамааруулж ерөнхийдөө Террачойс-ын ангилсантай адил ч дараах байдлаар авч үзсэн. Үүнд:

- Ногоон гэрэлтүүлэг (*Green-lighting*): Байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны сөрөг нөлөөг далдлах, түүнийг бууруулах бодит алхам хийгээгүй байж олон нийтээс нууцалж тэдний анхаарлыг сарниулах зорилгоор байгаль орчинд ээлтэй санаачилга, жижиг үйлдлээ онцолж сурталчилдаг. Ийм төрлийн ногоон угаалт нь олон нийтийн дунд

⁷ <https://planet-tracker.org/greenwashing-growing-increasingly-sophisticated-says-planet-tracker/>

- уг байгууллага нь байгаль орчныг хамгаалахад бодитой хувь нэмэр оруулдаг гэсэн ойлголтыг төрүүлдэг байна. Жишээ нь: Нефтийн томоохон компаниуд жил бүр мод тарих кампанит ажил зохион байгуулдаг ч нийт хөрөнгө оруулалтын 90 гаруй хувь нь уул уурхайн олборлолт, тээвэрлэлтийг дэмжсэн хэвээр байдаг.
- Ногоон шошго (*Greenlabelling*): Байгууллагууд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаль орчинд үзүүлэх бодит нөлөөллийг хэтрүүлэн харуулах, эсхүл буруу ойлголт төрүүлэх зорилгоор “ногоон”, “байгальд ээлтэй”, “100% байгалийн” зэрэг зохицуулалтгүй, тодорхой бус нэр томьёо, шошго, зураг ашиглах явдлыг хэлнэ. Энэ нь хэрэглэгчдийг төөрөгдүүлж, тухайн бүтээгдэхүүнийг экологийн хувьд аюулгүй хэмээн итгүүлдэг.
 - Чимээгүй ногоон (*Greenhushing*): Энэ угаалт нь буруутгагдахаас эмээх, ил тод мэдээлэл хийхдээ шаардлагатай баримт, нотолгоог дутуу өгөх, байгаль орчинд ээлтэй бодлого, үйл ажиллагаагаа олон нийтэд мэдээлэхээс зайлсхийх, санаатайгаар чимээгүй байх зэрэг зориудаар дутуу тайлагнах, нуун дарагдуулах үйлдэл юм. Жишээлбэл: 2022 онд олон улсын 1,200 гаруй компанийн тогтвортой байдлын тайланг судлахад 23 хувь нь зорилгоо дутуу илэрхийлсэн буюу “чимээгүй” хандлагыг баримталсан байна (South Pole, 2022).
 - Ногоон зайлалт (*Greenwashing*):
- Байгууллагууд байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй дүр эсгэх, хариуцлагаас зайлсхийхийн тулд ESG зорилтуудыг тогтмол өөрчлөх, шинэчлэх зэрэг олон нийтийг төөрөгдүүлдэг. Тухайлбал: Автомашин үйлдвэрлэгч 2025 он гэхэд нүүрс-төрөгчийн ялгаруулалтыг бууруулна гэж зорилт тавьсан ч хангаж чадахгүй болмогц хугацаагаа 2040 он болгож сунгах нь бодит ахиц дэвшилгүй, хариуцлагаас бултаж байна гэсэн үг.
- Ногоон шилжилт (*Green-shifting*): Байгууллага өөрийн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийн хариуцлагыг хүлээхийн оронд хэрэглэгчдэд эсхүл бусад оролцогч тал руу шилжүүлж тэднийг илүү ногоон сонголт хийхийг уриалж, бурууг шилжүүлдэг. Үүнд: Хуванцар сав үйлдвэрлэгчид “хэрэглэгчид дахин боловсруулахаар тушаахгүй байгаа нь асуудал” хэмээн бурууг хэрэглэгчид рүү чиглүүлэх.
 - Ногоон бөөгнөрөл (*Greencrowding*): Байгууллага бие даан хариуцлага хүлээхээс зайлсхийх зорилгоор олон байгууллагын хамтарсан кампанит “ногоон” санаачилгад нэгдэх замаар өөрийн байгууллагын сөрөг нөлөөллийг далдалдаг. Жишээ авч үзвэл: GFANZ (Glasgow Financial Alliance for Net Zero)-д зарим санхүүгийн байгууллагууд нэгдсэн ч бодит зээл, хөрөнгө оруулалтын бүтэц нь нүүрс-төрөгчийн ялгаруулалт буурахгүй өндөр хэвээр байна.

2.3. НОГООН УГААЛТААС ҮҮСЭХ ЭРСДЭЛ, ТҮҮНЭЭС СЭРГИЙЛЭХ НЬ

Цаг хугацаа өнгөрөх тусам нийгэмд тогтвортой хөгжил, байгаль орчны асуудалд анхаарал хандуулах нь ихсэж, ногоон угаалт нь зөвхөн энгийн хууран мэхлэлт биш, харин илүү нарийн төвөгтэй, танигдах боломжгүй хэлбэрт шилжиж нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ноцтой үр дагаврыг авчирч байгууллагын үйл ажиллагаанд дараах эрсдэлийг бий болгож байна. Үүнд:

- Нэр хүндээ алдах – Ногоон угаалтад өртөх нь санхүүгийн байгууллагын нэр хүндийг унагаж, зах зээл дэх байр суурийг нь сулруулан, өрсөлдөгчдөд нь давуу байдал олгодог. *Жишээ нь*, Харвардын Бизнесийн тойм сэтгүүлээс хийсэн судалгаагаар ногоон угаалт хийдэг компаниудын ACSI (Америкийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индекс) хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн оноо дунджаар 1.34 хувиар буурсан байгааг илтгэсэн. Энэхүү судалгаагаар ногоон угаалт нь «бүтээгдэхүүний нэр хүндийг унагах»-д шууд нөлөөлдөг болохыг тогтоосон.
- Үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг алдах: Үйлчлүүлэгчид байгууллагын тогтвортой байдлын талаарх мэдээлэл үнэн биш гэдгийг анзаарвал итгэл буурч, хөрөнгө оруулалтын урсгал нь саарч, цаашлаад тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх *Тухайлбал* нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг бууруулах зэрэг үйл явц удааширч болзошгүй. Үүнд 2021 онд McKinsey & Company-аас явуулсан судалгаагаар АНУ-ын Зет үеийн (Gen Z) хэрэглэгчдийн 88 хувь нь брэндүүдийн ESG-тай холбоотой мэдэгдэлд итгэдэггүй гэсэн хариулт өгчээ⁸.
- Хууль эрх зүйн үр дагавар: Сүүлийн 30 жилийн хугацаанд ESG-тэй холбоотой маргаантай нэхэмжлэлийн тоо 25 хувиар өссөн. Судалгаагаар ханган нийлүүлэлтийн сүлжээг хамарсан маргаан нэмэгдэхийн зэрэгцээ, байгаль орчин болон нийгмийн хариуцлагын хүрээнд үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчдэд үнэн зөв мэдээлэл өгөх, хэрэглэгчид мөн уг мэдээлэлд анхаарал хандуулах нь нэмэгдсэн. Үүнтэй уялдан, улс орнууд ногоон угаалт хийсэн этгээдүүдэд өндөр хэмжээний торгууль ногдуулах, хариуцлага тооцох тусгай зохицуулалт, дүрэм журмыг хэрэгжүүлэх болсон. *Жишээ* татвал, Европын холбоо (ЕХ)-ны Ногоон нэхэмжлэлийн заавар нь компаниудаас байгаль орчны нэхэмжлэлээ нотлох, баталгаажуулахыг шаарддаг. Хэрэв зөрчвөл өндөр торгууль ногдуулах, орлогыг нь хураах зэрэг хариуцлага тооцдог.
- Хөрөнгө оруулагчдаа алдах: Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад ESG хүчин зүйл ач холбогдолтой болохыг улам бүр мэдэрч

⁸ <https://www.linkedin.com/pulse/esg-matters-why-gen-z-demands-actions-promises-b9yue>

байна. ESMA-гийн 2023 оны 12 дугаар сарын тайланд дурдсанаар, ESG-ийн ач холбогдол өсөхийн хэрээр компаниуд байгаль орчны бодлогоо ил тод тайлагнах шаардлага нэмэгдэж байгаа бөгөөд үүнийг хангахгүй бол компанийн үнэлгээ, зэрэглэл буурч, хөрөнгө оруулалт татах чадвар сулрах эрсдэлтэй тулгарах болжээ гэж дүгнэсэн⁹.

- Зах зээлд нэвтрэх боломжоо алдах: Ногоон угаалт нь компанийн зах зээлд нэвтрэх боломжийг бүрмөсөн эсхүл тодорхой хугацаагаар хязгаарлаж болзошгүй. Хэрэв хэрэглэгчид худалдан авалтаараа хариу үйлдэл үзүүлбэл, ийм компаниуд зах зээлээс автоматаар шахагдах болно. Тухайлбал: GreenPrint-ийн 2021 оны судалгаагаар АНУ-ын хэрэглэгчдийн 75 хувь нь бүтээгдэхүүн худалдан авахдаа байгаль орчинд ээлтэй байдлыг чухалчилдаг гэсэн нь үүнийг нотолж байна. Мөн ЕХ-ны “Ногоон нэхэмжлэлийн удирдамж”-д ногоон угаалт хийсэн байгууллагыг төрийн худалдан авалтаас 12 сар хүртэл хугацаагаар хасах зохицуулалттай байдаг.

Байгууллагууд дараах дөрвөн үндсэн зарчмыг баримтлан ажиллах замаар ногоон угаалтаас сэргийлж байна. Үүнд:

1. Хариуцлагатай санхүүгийн зарчим:

Байгууллагууд богино хугацааны ашиг хөөхөөс илүүтэйгээр урт хугацааны өгөөжтэй, тогтвортой, байгаль орчинд ээлтэй шийдвэрүүдийг хэрэгжүүлж, хэрэглэгчид болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах;

2. Тогтвортой хөгжлийн зорилтууд: Байгууллага нь Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ) болон улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг өөрийн бодлого, үйл ажиллагаандаа уялдуулж, хэрэгжүүлснээр байгаль орчны хамгаалал, нийгмийн хариуцлага, эдийн засгийн өсөлтийг дэмжиж бодит үр дүнд хүрэх;
3. Ил тод байдал: Олон нийтийн итгэлийг хадгалахын тулд зөвхөн санхүүгийн тайлагнал бус бөгөөд байгууллагын ногоон зорилт, байгаль орчны нөлөөлөл, хариуцлагатай үйл ажиллагааны талаар бодит, ил тод мэдээлэл өгөх;
4. Санхүүгийн сахилга бат: Байгууллага нь хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүй, маркетинг, хүний нөөц, байгууллагын алсын хараа болон үйл ажиллагаанд хүндрэл үүсгэхээс сэргийлэхийн тулд санхүүгийн сахилга батаа тасралтгүй сайжруулж санхүүгээ хариуцлагатай удирдах.

⁹ https://www.esma.europa.eu/sites/default/files/2025-06/ESMA34-1592494965-764_Final_Report_on_2023-2024_CSA_on_sustainability.pdf

III. САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ НОГООН УГААЛТ

Энэхүү бүлэгт санхүүгийн салбар дахь шалтгаан, нийтлэг хэлбэрүүд болон олон ногоон угаалтын илрэл, түүний өсөлтийн улсын томоохон кейсийг авч үзнэ.

3.1. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОРОЛЦОО БА НОГООН УГААЛТЫН ӨСӨЛТ

Санхүүгийн байгууллагууд нь ногоон хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтыг чиглүүлэгч үндсэн механизм учраас тэдний ил тод байдал, хариуцлага өндөр байх нь чухал ач холбогдолтой. Иймээс тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэмжих олон улсын санаачилгад санхүүгийн салбарын оролцоог нэмэгдүүлэхийг уриалсаар ирсэн. Үүнд:

- Дэлхийн Банкны харьяа Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ын удирдлага дор “Экваторын зарчмууд”¹⁰ (2003)-ыг баталсан. Экваторын зарчмууд нь төслийн санхүүжилтийн нийгэм, байгаль орчны эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах боломжийг олгодог. Өдгөө 100 гаруй санхүүгийн байгууллага уг зарчмыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.
- НҮБ-аас “Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчим” (Principles for Responsible Investment)¹¹-ыг санаачилж

хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад ESG-ын хүчин зүйлсийг тусган хариуцлагатай хангахыг уриалсан. Энэхүү зарчмыг 5,300 гаруй байгууллага дэмжиж, албан ёсоор гарын үсэг зураад байна.

- Парисын хэлэлцээр (2015): Уг хэлэлцээрийн зорилтуудын нэг нь санхүүгийн урсгалыг хүлэмжийн хийн ялгарал багатай, уур амьсгалд тэсвэртэй хөгжилд чиглүүлэх¹² явдал юм. Учир нь уг зорилт санхүүгүйгээр хэрэгжих боломжгүй¹³ гэжээ.
- Шотландын Глазго хотноо 2021 онд зохион байгуулагдсан НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн бага хурал (COP26)-д оролцсон 70 их наяд ам.долларын хөрөнгийг удирдаж буй дэлхийн 160 гаруй санхүүгийн байгууллага 2050 он гэхэд цэвэр хүлэмжийн хийн ялгаруулалтыг тэглэх зорилтыг дэмжин, албан ёсоор амлалт өгсөн¹⁴. Энэхүү

¹⁰ Equator principles Action report 2023 page 3

¹¹ <https://www.unpri.org/about-us/what-are-the-principles-for-responsible-investment>

¹² Article 2.1 of the Paris Agreement indicates as objectives: (1) to hold the increase in the global average temperature to well below 2°C above pre-industrial levels and pursue efforts to limit the temperature increase to 1.5°C (article 2.1a), (2) to promote climate resilience development (article 2.1b), (3) Article 2.1c https://unfccc.int/sites/default/files/english_paris_agreement.pdf

¹³ Intergovernmental Panel on Climate Change (IPCC), Climate Change Synthesis Report; page 1553., 2023 https://www.ipcc.ch/report/ar6/syr/downloads/report/IPCC_AR6_SYR_SPM.pdf

¹⁴ <https://www.un.org/en/climatechange/biggest-financial-players-back-net-zero>

санаачилгад санхүүгийн салбарыг голлох үүрэг гүйцэтгэнэ хэмээжээ. Өнөөдөр дэлхийн 193 орон тогтвортой хөгжлийн төлөөх арга хэмжээнүүдийг дэс дараатайгаар авч хэрэгжүүлэх, хүлэмжийн хийг бууруулахаар амлалт өгч хэрэгжүүлж байна.

- 2023 онд Куньмин–Монреалийн “Биологийн олон янз байдлын конвенц”–ыг баталсан ба үүний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн 30 хувийг байгаль хамгаалах зорилтод нийцүүлэх шаардлагыг тусгасан¹⁵.

Дээр дурдсанаас үзэхэд санхүүгийн салбар нь нөөцийг хуваарилах үндсэн механизмын хувьд байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөрөө стратегийн чухал оролцогч болж байна.

Ийнхүү байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, цэвэр хүлэмжийн хийн ялгаруулалтыг тэглэх зорилгод хүрэх олон улсын амлалтууд нь ногоон эдийн засгийн эрэлтийг нэмэгдүүлэхтэй зэрэгцэн “ногоон угаалт” үзэгдэл өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ талаар:

- Лондоны Биркбекийн Их Сургуулийн харьяа Инновацын менежментийн судалгааны төв (CIMR) (2020)¹⁶ ESG–ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, томоохон хөрөнгийн багцтай компаниудын зан төлөвийг шинжилж судалжээ. Судалгааны дүгнэлтэд компаниуд ESG–ын хүрээнд олсон ололт амжилтаа хэтрүүлэн үнэлж, бодит байдлаас зөрүүтэй мэдээлэл түгээх замаар ногоон угаалт хийж буйг онцолсон байна.

- Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) хэмжигдэхүүнээр мэргэшсэн мэдээллийн компани болох RepRisk–ийн 2023 оны есдүгээр сард нийтэлсэн тайланд дэлхийн банк санхүүгийн үйлчилгээний салбарт ногоон угаалтын 148 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 86–аар их буюу 70 хувиар өссөн¹⁷ гэжээ.


Дэлхийн хэмжээнд ногоон, нийгмийн, тогтвортой бонд гаргах нь 2021 онд 1 их наяд доллароос давж, 2018 онтой харьцуулахад бараг 5 дахин өссөн гэж S&P Global үзэж байна.

¹⁵ Principles for Responsible Investment <https://www.unpri.org/about-us/what-are-the-principles-for-responsible-investment>

¹⁶ <https://eprints.bbk.ac.uk/id/eprint/30701/1/Greenwashing%20in%20environmental%2C%20social%20and%20governance%20disclosures%20from%20Ellen%20Yu.pdf>

¹⁷ <https://www.tradefinanceglobal.com/posts/report-greenwashing-incidents-up-70-globally-2023/>


Зураг 1. Тогтвортой өрийн хэрэгсэл



*Data through June 30, 2021. Source: Environmental Finance and S&P Global Ratings. Copyright © 2021 by Standard & Poor's Financial Services LLC. All rights reserved..

Үүнтэй зэрэгцэн Дэлхийн санхүүгийн салбарт л гэхэд 2018 оноос 2023 он хүртэл ногоон угаалтын тохиолдол ойролцоогоор 10 дахин (Зураг 2) нэмэгджээ.

Зураг 2. Санхүүгийн салбар дахь ногоон угаалтын тохиолдол



Source: RepRisk
*Annual value extrapolated from months of data from January to September




Нийгэм, шилжилтийн болон тогтвортой байдалтай холбоотой санхүүжилтийн шинэ хэрэгсэлүүд нэмэгдсээр байгаа тул хөрөнгө оруулагчид ногоон болон тогтвортой байдлын угаалтад санаа зовнил нь нэмэгдсээр байна.

3.2. НОГООН УГААЛТЫН ИЛРЭХ БАЙДАЛ

Ногоон угаалт санхүүгийн салбарт дараах байдлаар нийтлэг илэрдэг. Үүнд:

- Төсөл, хөтөлбөр: Хөрөнгө оруулагчдад “ногоон” гэж тодорхойлсон төсөл, хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийх урам зориг өгдөг ч, бодит байдалд



тэр нь экосистемд сөргөөр нөлөөлдөг. *Жишээ нь*: Малайзын Селангор мужийн Сиера Алам төсөл нь “байгаль орчинд ээлтэй, нийгмийн сайн сайхны төлөө” гэх шошгоор хөрөнгө татсан ч бодит байдалд уулын бэл хэсгийг ухаж, экосистемийг доройтуулсан, үерийн эрсдэлийг нэмэгдүүлсэн, олон зүйлийн амьтан, ургамлын амьдрах орчныг устгасан нь тогтоогдсон. 2022 оны тайланд тус бүс нутаг 4000 га ойгоо алдаж, биологийн төрөл зүйл буурсан гэж дурджээ.

- Ногоон бонд: Тус бондыг гаргагчид хөрөнгө оруулагчдад татан төвлөрүүлсэн хөрөнгийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой төслүүдэд зарцуулна гэж амладаг. Гэвч бодит байдал дээр хөрөнгийг анхны зорилгоос өөр зүйлд ашиглах, эсхүл




үр нөлөө нь бодитоор үнэлэгдэхгүй тохиолдол байдаг. *Жишээ нь*, JBS S.A компани 2021 онд 3.2 тэрбум ам.долларын “тогтвортой байдлын холбоотой бонд” гаргасан ч Амазоны ой модод үзүүлэх сөрөг нөлөөллийг бодитоор төлөвлөгөөгүй, хүлэмжийн хийн бууралтаа нотолгоогүй, орхигдуулсан гэж буруутгагдаж байжээ (2024).

- Ногоон зээл: Энэ нь байгаль орчинд ээлтэй, тогтвортой төслүүдэд зориулагдах байтал тодорхой шалгуур, үнэлгээний системгүйгээр олгосон болно. *Тухайлбал*, Австралийн Үндэсний банк 2021 онд нүүрсний экспортын боомтод “ногоон” зээл олгосон нь бодитоор нүүрс ашиглалтын хугацааг уртасгасан тул



ногоон угаалтын жишээ болсон.¹⁸

- Ногоон шошго: Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний бодит



агуулга, үр нөлөөгүйгээр “экологийн”, “тогтвортой”, “ногоон” гэх мэт нэр томъёог ашиглаж, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдыг төөрөгдүүлэх практик юм. Жишээ нь, Lloyds Banking Group олон нийтийн газарт “Бид чулуужсан түлшний хараат байдлаа бууруулж, санхүүгийнхээ жинг цэвэр, сэргээгдэх эрчим хүч рүү чиглүүлэх замаар эрчим хүчний шилжилтийг дэмжих үүрэг хүлээсэн.” гэж сурталчилсан

нь үнэн хэрэгтээ чулуужсан түлшний санхүүжилтээ үргэлжлүүлж бодит байдалд нийцээгүй, төөрөгдүүлэх мэдээлэл болсон.

- ESG мэдээллийн тайлан: Байгаль орчны нөлөөллийг нуух, дутуу эсхүл хэтрүүлсэн мэдээлэл оруулж тайлагнадаг. Жишээ нь Rio Tinto



компани байгаль орчны нөлөөллийг бууруулах, усны менежментээ сайжруулах амлалт өгсөн¹⁹ ч 2023 оны тогтвортой байдлын тайланд усны бохирдлын асуудлаа дурдаагүй гэж хөрөнгө оруулагчдын зүгээс шүүмжлүүлсэн.

3.3. ДЭЛХИЙГ ДОНСОЛГОСОН ТОМООХОН КЕЙСҮҮД

Дэлхийн хэмжээнд донсолгосон томоохон компаниудын үйлдсэн “ногоон угаалт”-ын жишээнүүдийг авч үзье.

3.3.1. DWS

Германы хөрөнгө удирдлагын компани DWS Group нь Франкфурт хотод төвтэй, 40 гаруй оронд салбартай Deutsche Bank-ийн охин компани бөгөөд хөрөнгө удирдлагын



¹⁸ <https://sustainabilityunlocked.com/videos/greenwashing-3-3-case-studies>

¹⁹ https://www.google.com/search?q=abc+mining+llc+greenwashing+scandal&sca_esv

салбарт тэргүүлэгчдийн нэгт тооцогддог. Тус компани өөрсдийгөө 2020 оноос хойш “ESG бол бидний Дезоксирибонуклейн хүчил (ДНХ)-ийн нэг хэсэг”, “ESG-ын чиглэлээр манлайлагч” хэмээн сурталчилсан. АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (SEC) болон Германы Франкфуртын прокурорын газар хамтран мөрдөн шалгалтыг эхлүүлж, 2022 оны тавдугаар сард DWS болон Deutsche Bank-ийн Франкфурт дахь салбаруудыг нэгжиж улмаар компанийн сурталчилсан ESG хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийн зарим нь бодит байдал дээр тогтоосон шалгуурыг хангаагүй, сурталчилгааны мэдээлэл нь хэтрүүлэгтэй, төөрөгдүүлсэн болохыг нотолсон.

Ийнхүү 2023 онд АНУ-ын SEC-ийн зүгээс DWS-т 19 сая ам.долларын торгууль оногдуулсан бол, 2025 онд Германы Франкфуртын прокурорын газар 3 жилийн турш хийсэн мөрдөн шалгалтын үр дүнд DWS-г ногоон угаалт хийсэн хэмээн дүгнэж, Deutsche Bank-ны нийт орлогод үндэслэн 25 сая еврогийн (ойролцоогоор 27 сая ам.доллар) торгууль ногдуулжээ²⁰. Энэ нь ESG зөрчилтэй холбоотойгоор Германд оногдуулсан хамгийн өндөр дүнтэй шийтгэл болсон.

DWS компанийн зүгээс эдгээр торгуулийг хүлээн зөвшөөрч, дотоод хяналт шалгалт, баримт бичгийн бүрдүүлэлт болон маркетингийн үйл ажиллагаандаа сайжруулалт хийх арга хэмжээ авсан болохоо мэдэгдсэн.

3.3.2. Goldman Sachs

Goldman Sachs Asset Management (GSAM) нь Goldman Sachs группийн хөрөнгө удирдлагын салбар компани бөгөөд хувь хүн, байгууллага, тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан зэрэг харилцагчдад чиглэсэн төрөл бүрийн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог. Тус байгууллага нь 2.5 их наяд ам.доллар орчмын хөрөнгийг удирдаж, дэлхийн 30 гаруй оронд салбартай томоохон тоглогчдын нэг юм.



2020 оноос GSAM компани нь ESG хөрөнгө оруулалтыг эрчимтэй сурталчилж, бүх төрлийн хөрөнгө оруулалтын шийдвэрт ESG-ын шалгуурыг нэгтгэн тусгаж ажилладаг хэмээн мэдэгдэж байсан. Тухайлбал тус компанийн US Equity ESG Fund болон International Equity ESG Fund нэртэй хоёр сан нь “Бид хөрөнгө оруулалтын үйл явцдаа ESG-ын хүчин зүйлсийг тусган хэрэгжүүлдэг.”, “Манай ESG сангууд хатуу шалгуурын дагуу хөрөнгө оруулалт хийдэг”, “Хөрөнгө оруулагчид өөрсдийн үнэт зүйлтэй нийцсэн хөрөнгө оруулалт хийх боломжтой” гэх мэт зар сурталчилгааг олон нийтэд түгээсэн. SEC нь 2021 оноос хойш

²⁰ <https://www.esgtoday.com/deutsche-banks-dws-fined-27-million-for-greenwashing/>

ESG-тэй холбоотой хөрөнгө оруулалтын ил тод байдал, тайлагналд онцгой анхаарал хандуулж ESG сангуудыг шалгах тусгай нэгж байгуулж хяналт шалгалтыг эхлүүлсэн. Ингэснээр 2022 онд тус байгууллагын ESG чиглэлийн хөрөнгө оруулалтын бодит байдал болон сурталчилгааны зөрүүтэй холбоотой дотоод шалгалт хийж “Зарим хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа ESG үнэлгээний шалгуур, мэдээлэл ашиглаагүй”, “сурталчилгаа нь бүх хөрөнгөд ESG шалгуур хэрэглэдэг гэсэн ойлголт төрүүлж байсан боловч бодит үйл ажиллагаанд зарим сан нь энэ шалгуурыг огт ашиглаагүй”, “ESG үнэлгээний баримтжуулалт, дотоод хяналтын процесс хангалтгүй” болохыг тогтоосон. SEC-ийн зүгээс GSAM-ийг “худал мэдэгдэл, дутуу тайлагнал хийсэн” хэмээн үзэж, 4 сая ам.долларын торгууль оногдуулсан²¹. Тус компани энэхүү шийтгэлийг хүлээн зөвшөөрч, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээ мэдэгдсэн:

- ESG хөрөнгө оруулалтын процессын ил тод байдлыг нэмэгдүүлэх,
- Сурталчилгаа, баримт бичгийн агуулгыг шалгах хяналтыг сайжруулах,
- ESG үнэлгээний шалгуурыг бүх сандаа ашиглах.

3.3.3. BNY Mellon

BNY Mellon Investment Adviser Inc. нь Bank of New York Mellon Corporation-ийн хөрөнгө



удирдлагын салбар компани. Тус компани нь Goldman Sachs-тай ижил төстэй буюу ESG хөрөнгө оруулалтын талаар худал мэдээлэл өгсөн гэх хэргээр 2022 онд SEC-ээс шалгалт орсон. SEC-ээс тус компанийн сурталчилгаанууд нь бодит байдлыг гуйвуулсан болох нь тогтоогдсон²². Үүнд тодорхой хөрөнгө оруулалтууд нь огт ESG үнэлгээ хийгдээгүй, эсхүл ESG шалгуурын дагуу биш байхад, угсанд орсон бүх хөрөнгийг ESG шалгуураар бүрэн дүгнэсэн мэтээр илэрхийлсэн гэж үзсэн. Энэ нь хөрөнгө оруулагчдад худал мэдээлэл өгч, шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлсөн гэж дүгнэжээ. Иймээс SEC нь BNY Mellon Investment Adviser Inc.-ийн үйлдлийг Хөрөнгө оруулалтын зөвлөхийн тухай хуулийн 206(2) дахь заалт “хуурмаг, төөрөгдүүлсэн мэдээлэл тараах”, 206(4)-7, 8 дэх “бодлогын дагуу зохих хяналт хийхгүй байх”, 34(b) дэх “хөрөнгө оруулалтын компанийн хуульд үндэслэсэн мэдээллийг худал илэрхийлэх”-ийг тус тус зөрчсөн хэмээн үзэв²³. SEC-ийн зүгээс 2022 онд тус компанид 1.5 сая ам.долларын торгууль оногдуулжээ.

²¹ <https://sustainability-news.net/industries/finance/goldman-sachs-fined-4-million-over-esg-violations/>

²² <https://www.sec.gov/newsroom/press-releases/2022-86>

²³ <https://www.petersandpeters.com/case/bny-mellon-charged-for-esg-quality-review-misstatements/>

IV. НОГООН УГААЛТЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ БА УЛС ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү бүлэгт олон улсын стандарт зүйн зохицуулалтын талаар танилцуулж, болон улс орнуудад мөрдөгдөж буй эрх харьцуулсан шинжилгээ хийлээ.

4.1. ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

Судалгаанд сонгон судалсан нэр бүхий 3 стандарт нь байгууллагуудыг бодит мэдээлэлд суурилж тайлагнах, байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг үнэлэх нийтлэг арга зүй, шалгуурыг санал болгодог.

4.1.1. Global reporting initiative (GRI)

GRI²⁴ нь байгууллагуудын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг ил тод болгох, үнэлэн тайлагнах замаар хариуцлагатай, тогтвортой үйл ажиллагааг дэмжих олон улсын стандартын систем юм. Анх 1997 онд АНУ-ын Байгаль орчинд хариуцлагатай эдийн засгийн эсхүл (Climate change and European Aquatic RESources (CERES))²⁵ болон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (United Nations Environment Programme (UNEP))-ийн хамтарсан санаачилгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд 2002 оноос хойш Нидерландын Амстердам хотод төвтэй, хараат бус ашгийн бус байгууллага болон ажиллаж байна.

GRI стандартууд нь дэлхий даяарх компаниудын хамгийн түгээмэл хэрэглэгддэг стандарт юм. Тус стандартуудыг сайн

дурын үндсэн дээр мөрддөг тул том, жижиг аль ч байгууллага байршлаасаа үл хамааран ашигладаг. Учир нь тэрээр бизнес эрхлэгчдэд өөрсдийн бизнесийн загварт хамгийн их хамааралтай ESG сэдвүүдийг сонгох боломжийг олгодог.

GRI стандартууд нь гурван үндсэн бүлэгт хуваагддаг:

- Ерөнхий стандартууд – бүх байгууллагад хамаарах зарчим, зааварчилгаа;
- Сэдэвчилсэн стандартууд – байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлууд;
- Салбарын стандартууд – тодорхой салбаруудын онцлогт нийцсэн стандартууд (жишээ нь хүлэмжийн хийн ялгаралт, усны хэрэглээ, хөдөлмөрийн нөхцөл гэх мэт).

Стандартууд нь байгууллагын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлтэй холбоотой тогтвортой байдлын гол асуудлуудад төвлөрсөн.

Ногоон угаалтыг хязгаарлах чиглэлд GRI стандарт нь бүтээгдэхүүнийг гуйвуулан сурталчлахыг бууруулах, үүнтэй тэмцэхэд хэд хэдэн үр дүнтэй арга замыг хэрэгжүүлж байна. Тухайлбал:

²⁴ <https://www.globalreporting.org/>

²⁵ <https://www.ceres-cert.de/en/home>

- GRI нь материаллаг асуудлын шалгуур (*Materiality criteria*) тавьсан нь тухайн байгууллага бодитоор хамаарах, түүний үйл ажиллагаанд чухал нөлөөтэй асуудлуудыг тодорхойлох боломжтой болгосон. Ингэснээр тайлагналд ач холбогдолгүй эсвэл гуйвуулагдсан мэдээлэл тайлагнах нь багассан. Энэ стандартууд нь зөвхөн байгууллагын эерэг үр дүнг бус, аливаа сөрөг үр дүнг ч мөн тайлагнахыг шаардана. Ингэснээр компаниудын гүйцэтгэлийг илүү үнэн зөвөөр тусгах, ногоон угаалтыг сааруулах гол механизм болдог.
- GRI-ийн оролцогч талуудын оролцоог хангах зарчим (*Stakeholder inclusiveness*) нь тайлагналд зөвхөн байгууллагын өөрийн байр сууриас гадна хөндлөнгийн байгууллагын дүгнэлтийг тусгах боломжийг олгодог. Ингэснээр тус тайлан илүү өргөн хүрээний үнэлгээ, дүгнэлтийг агуулах бөгөөд төөрөгдүүлсэн мэдээлэл гарахаас сэргийлж чадна.
- GRI-ийн шаардлагаар тайлан нь ил тод, бүрэн бүтэн байх нөхцөлийг хангасан тохиолдолд “GRI-т нийцсэн” (*GRI conformant*) гэж албан ёсоор хүлээн зөвшөөрч гэрчилгээ олгодог. Уг гэрчилгээ нь тухайн тайлан нь стандартын дагуу үнэн зөв, гүйцэд, ил тод байдлыг хангасан болохыг батална.

GRI стандартууд бол уян хатан, бүх салбарт хэрэгжих боломжтой нийгэм, байгаль орчны нөлөөллийг цогц тусгасан тайлагналын аргачлал боловч санхүүгийн үнэлгээтэй холбогдох нь харьцангуй сул болно.

4.1.2. Sustainability Accounting Standards Board (SASB)

SASB²⁶ нь хөрөнгө оруулагчдад зориулсан, салбар бүрийн хувьд онцгой ач холбогдолтой тогтвортой хөгжлийн асуудлуудыг нягтлан бодох бүртгэл, тайлагналын хэлбэрээр ил тод болгоход чиглэсэн стандартын тогтолцоо юм.

SASB нь 2011 онд АНУ-ын ашгийн бус байгууллагаар байгуулагдсан бөгөөд 2021 онд Value Reporting Foundation (VRF)-тай, 2022 онд VRF-г International Financial Reporting Standards Foundation (IFRS Foundation (IFRSF))-тай тус тус нэгтгэсэн. SASB стандартууд нь International Sustainability Standards Board (ISSB)-ийн зохицуулалт дор орсон бөгөөд IFRS S1 ба S2 стандартуудтай уялдсан хэлбэрээр хэрэглэгдэж байна.

SASB нь нийт 77 салбарт зориулсан тусгай стандартуудыг боловсруулсан бөгөөд эдгээр нь тухайн салбарын эдийн засаг, нийгэм, байгаль орчны нөлөөлөлд хөрөнгө оруулагчийн шийдвэрт шаардлагатай шууд нөлөөлөх мэдээллийг тодорхойлох замаар ажилладаг. Стандарт бүр дараах таван үндсэн ангилалд хамаарах асуудлыг тусгасан байдаг:

²⁶ <https://sasb.ifrs.org/>

- Байгаль орчны үйл ажиллагаа;
- Нийгмийн капитал;
- Хүний капитал;
- Бизнесийн загвар ба инновац;
- Засаглал ба манлайлал.

SASB-ийн гол онцлог нь өмнө дурдсанчлан зөвхөн хөрөнгө оруулагчийн шаардлагад нийцсэн, санхүүгийн хувьд ач холбогдолтой тогтвортой байдлын мэдээлэлд төвлөрдөг.

SASB-ийн давуу тал нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, байгууллагуудад эрсдэлийг тодорхойлох, удирдах боломжийг олгох, шийдвэр гаргах чадварыг сайжруулахад оршдог тул салбар хоорондын харьцуулалтыг илүү сайн болгодог.

Өөрөөр хэлбэл уг стандарт ногоон угаалтыг бууруулж байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн үр дагаврыг илүү бодитоор харуулах замаар ил тод байдлыг дэмждэг.

Ногоон угаалтыг хязгаарлах чиглэлд SASB нь мэдээллийг тоон үзүүлэлт дээр суурилан тайлагнахыг зөвлөдөг. Тухайлбал,

- Энергийн хэрэглээ (KWh)
- Нүүрстөрөгчийн ялгаруулалт (тонн CO₂e)
- Усны хэрэглээ, бохир ус цэвэрлэх арга гэх мэт.

SASB нь тайлагнал дахь ногоон угаалтыг илрүүлж, илүү үнэн бодитой мэдээллийг

олон нийтэд хүргэдэг. Учир нь:

- SASB нь тайлан дахь материаллаг мэдээлэл (*Material disclosures*)-д дүн шинжилгээ хийж хэрэв онцгой ач холбогдолтой, бизнесийн үр өгөөжид шууд нөлөөлөх асуудлыг дурдаагүй гэж үзвэл уг байгууллага ногоон угаалт хийсэн гэж үнэлэгдэх боломжтой.
- SASB нь санхүүгийн зах зээлд чиглэсэн, өндөр нарийвчлалтай, хэмжигдэхүйц үзүүлэлтүүдэд суурилсан тогтвортой байдлын тайлагналын систем болохын хувьд, ESG мэдээллийн ил тод байдал, үнэн зөв байдлыг хангадаг.

4.1.3. ISO 14030 стандарт

ISO 14030 нь 2021 онд батлагдсан “Environmental performance evaluation – Green debt instruments” нэртэй бөгөөд “ногоон зээл болон бонд” гэх мэт санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх, төсөл буюу хөрөнгө ашиглалт, үр дагавар, тайлан ба баталгаажуулалтын хувьд “ногоон” эсэх нь тодорхой, үнэн зөв, ил тод байх зарчим, шаардлагыг баримтлах үүднээс боловсруулагдсан олон улсын стандарт юм. Уг стандарт 4 хэсгээс бүрдэнэ.

Үүнд:

Хүснэгт 1. ISO 14030 стандарт

Стандарт	Зориулалт	Шаардлага
ISO 14030–1:2021 “Environmental performance evaluation — Green debt instruments — Part 1: Process for green bonds”	Бонд гаргагч (issuer)–д зориулагдсан ²⁷	<ol style="list-style-type: none"> 1. Ил тод, үнэн зөв, хариуцлага, урьдчилан сэргийлэх зарчим тодорхойлох; 2. “төсөл, хөрөнгө ба хөрөнгө зарцуулалт” тодорхойлох; 3. санхүүгийн хөрөнгөө хэрхэн хэрэглэх, хэрхэн хянахаа илэрхийлэх; 4. байгаль орчны үр дагавар болон тухайн төслүүдийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тогтоох; 5. тайлан, олон нийт болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх; 6. баталгаажуулалт (гадаад талын үнэлгээ, баталгаажуулалт).
ISO 14030–2:2021 “Part 2: Process for green loans”	Зээл хүсэгчид болон зээл олгогч талуудад зориулсан ²⁸	<ol style="list-style-type: none"> 1. Зээлийн санхүүжилт хаашаа яаж зарцуулагдах; 2. төслүүдийн сонголт, шалгуур үзүүлэлт; 3. байгаль орчны үр дагавар, үр ашигт үзүүлэх нөлөөлөл; 4. тайлагнал ба мэдээлэл солилцох байдал; 5. баталгаажуулалттай эсэх, олон талын үүрэг; 6. ялангуяа зээл стандартчилсан эсэхээс хамаарч зээл олгогч эсэх, зээл авагч нь ямар үүрэг хүлээх.
ISO 14030–3:2022 “Part 3: Taxonomy”	Ногоон санхүү, бонд болон зээлийн хэрэгслүүдийн төсөл, хөрөнгө, зарцуулалт, хөрөнгө оруулалтын ангилал, шалгуур үзүүлэлтүүд, хориглолт гэх мэтийг тодорхойлох ²⁹	<p>Энэ стандарт нь ISO 14030–1 ба 2 стандартуудын дагуу:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эдийн засгийн салбарт ногоон төсөл/хөрөнгө/зарцуулалтын ангилал; 2. хүрээлэн буй орчны бодит нөхцөл, тухайн бүс нутгийн байгаль орчны төлөв; 3. босго, эсвэл шалгуур үзүүлэлтүүд (жишээ нь ялгаруулалтыг багасгах хэмжүүр, энергийн үр ашиг); 4. ямар төсөл болон хөрөнгийг ногоон гэж тооцохгүй болохыг тодорхойлсон; 5. урьдчилсан нөхцөлүүд ба taxonomy ашиглах боломж; 6. үзүүлэлт, аргачлалын зааврууд (Annex A, B).
ISO 14030–4:2021 “Part 4: Verification programme requirements”	Баталгаажуулалт, хүчинтэй байгууллагуудын шаардлага, зөвлөмж ³⁰ .	<p>Энэ стандарт нь ISO 14030–1, ISO 14030–2 ба ISO 14030–3 эсвэл оронд нь ашиглагдах taxonomy–г дагаж мөрдөж буй зээл, бонд, төслүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тайлан, үр ашиг зөв хийх; 2. мэргэшсэн, ёс зүйн хувьд хараат бус буюу шударга байх; 3. үйлчилгээ үзүүлэгч байгууллагын чадавх, мэргэжлийн баталгаа; 4. марк/тэмдэг ашиглах үед тэр нь хууль ёсны болон тохирох гэрээ зэрэгтэй байх; 5. хэрвээ төсөл эсвэл хөрөнгө “таксоному”–той нийцэхгүй тохиолдолд эрхийн баталгаажуулалт хийх; 6. ашиглагдах стандартууд (жишээ нь бусад ISO/IEC 17029, ISO 14065, ISO/IEC 17030) эсэхтэй уялдах болон шаардлагуудыг хадгалах.

²⁷ <https://www.iso.org/obp/ui/en/#iso:std:iso:14030:-1:ed-1:v1:en>

²⁸ <https://cdn.standards.iteh.ai/samples/75558/191bb52cd1094b21abe88c7b7035660a/ISO-14030-2-2021.pdf>

²⁹ <https://www.iso.org/standard/75559.html>

³⁰ <https://www.iso.org/standard/76598.html>

Стандарт нь хөрөнгө оруулагчид болон бусад сонирхогч талуудад санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн хүрээлэн буй орчинд үзүүлэх эерэг нөлөөг нотолгоонд суурилан үнэлэх боломжоор хангадаг.

ISO 14030 стандарт нь тоон үндэслэлгүй “ногоон” сурталчилгаа хийхийг хориглох замаар эрсдэлийг бууруулдаг. Үүний тулд

- Тухайн санхүүгийн бүтээгдэхүүнийг “ногоон” гэж ангилахын тулд зөвхөн нэршилд бус, бодитой хэмжигдэхүйц үр дүн шаардагддаг. Үүнд, нүүрс-төрөгчийн давхар ислийн (CO₂) ялгаруулалтын бууруулалт, эрчим хүчний хэмнэлт гаргасан зэрэг нь тоон үзүүлэлтүүдэд үндэслэгдсэн байна. Энэ шалгуур нь компанид “ногоон” имижтэй бүтээгдэхүүн сурталчлахын тулд зайлшгүй үр дүнгээ нотолж тайлагнах шаардлага үүсдэг.

- Тайлагналын тогтмол давтамжтай үе шатыг тогтоож, тухайн бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалт хэрхэн хэрэгжиж байгааг хугацааны явцад хянах боломж бүрдүүлдэг. Мөн гаднын аудит, хөндлөнгийн үнэлгээний байгууллагуудаар баталгаажуулалт хийлгэхийг санал болгодог нь мэдээллийн үнэн зөв байдал, ил тод байдлыг нэмэгдүүлдэг.

Тус стандартуудыг Засгийн газрын байгууллагууд, банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын сангууд, байгаль орчны үнэлгээ хийдэг зөвлөх компаниуд өргөн ашиглах боломжтой.

4.1.4. Стандартуудын харьцуулалт ба Монголд хэрэглэх шийдэл

Дээр дурдсан стандартуудыг хооронд нь харьцуулж шинжвэл:

Хүснэгт 2. Стандартуудын зорилго

Стандарт	GRI ³¹ 	SASB ³² 	ISO 14030 ³³ 
Зорилго	Байгууллагын эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг ил тод тайлагнах	Салбар тус бүрийн санхүүгийн ач холбогдол бүхий ESG мэдээллийг хөрөнгө оруулагчдад ил тод болгох	Ногоон санхүүжилтийн төсөл, бүтээгдэхүүний байгаль орчны үр нөлөө гүйцэтгэлийг нотолгоотойгоор үнэлэх, баталгаажуулах

³¹ <https://www.globalreporting.org/>

³² <https://sasb.ifrs.org/>

³³ <https://www.iso.org/home.html>

Эндээс ISO 14030 стандарт нь үйл ажиллагааны чанарыг сайжруулах, GRI стандарт нь олон нийт, олон улсын хэрэглэгчдэд итгэл төрүүлэх, SASB стандарт нь хөрөнгө оруулагчийн итгэлийг татахад оновчтой нь харагдаж байна.

Монгол Улсын эдийн засаг нь уул уурхай, хөдөө аж ахуй, эрчим хүч зэрэг байгаль орчинд өндөр нөлөөтэй салбарт төвлөрдөг бөгөөд эдгээр салбарт экспортын чиг баримжаа давамгайлдаг тул тогтвортой байдлын тайлагнал нь олон улсын шаардлагад нийцэх зайлшгүй хэрэгцээтэй.

Иймд жижиг, дунд үйлдвэрлэл болон ханган нийлүүлэгч байгууллагуудад ISO зэрэг менежментийн тогтолцооны стандартууд илүү тохиромжтой бөгөөд эдгээр нь дотоод үйл ажиллагааг бодитоор сайжруулж, хөндлөнгийн аудит, гэрчилгээжүүлэлт зэрэг нь итгэл төрүүлнэ. Харин олон нийт

болон хэрэглэгчийн итгэлцэлд өндөр ач холбогдолтой уул уурхай, боловсруулах үйлдвэр, санхүүгийн байгууллагууд GRI-ийг хэрэглэх нь ил тод байдлыг хангаж, нийгмийн хариуцлагыг харуулах боломжтой.

Тэгвэл гадаадын хөрөнгө оруулалт татах, IPO хийх, олон улсын санхүүгийн зах зээлд өрсөлдөх зорилготой компаниудад SASB стандарт нь хамгийн оновчтой ба энэ нь хөрөнгө оруулагчдад санхүүгийн ач холбогдол бүхий ESG мэдээллийг өгч шийдвэр гаргалтад нь нөлөөлнө.

Энэ бүгдээс дүгнэхэд Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын хувьд нэг стандартыг дангаар хэрэглэхээс илүү тухайн салбар, зорилго, ашиг сонирхлын бүлгээс хамаарч ISO, GRI, SASB-ийг уялдуулан хослуулж хэрэглэх нь ногоон угаалтаас сэргийлэх хамгийн үр дүнтэй арга байх боломжтой.

4.2. УЛС ОРНУУДЫН ЗОХИЦУУЛАЛТ

Ногоон угаалтыг багасгахын тулд улс орнууд хууль эрх зүйн акт боловсруулж мөрдөн ажиллаж байна. Зарим улс орнууд зах зээлийн бүх салбарт үйлчлэх ерөнхий хууль (жишээ нь, шударга бус арилжааны эсрэг зохицуулалт), зар сурталчилгааны нийтлэг дүрэм, эсхүл тусгайлан санхүүгийн зах зээл тэр дундаа үнэт цаастай холбоотой тусгай журамд тусгах зэрэг болно.

4.2.1. Европын холбоо (ЕХ)

ЕХ нь тогтвортой хөгжлийг дэмжих

бодлого, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохицуулалтын тогтолцоо, ногоон угаалтыг хязгаарлах эрх зүйн арга хэмжээгээрээ дэлхийд тэргүүлэгч бүс нутагт тооцогддог. Тус холбоо нь санхүүгийн байгууллага болон бизнесийн байгууллагуудаас байгаль орчны талаарх мэдээллийг үнэн зөв, ил тод, нотолгоонд тулгуурласан байдлаар тайлагнах өндөр шаардлагыг тавьж, зохицуулалтын хүрээг тогтмол өргөжүүлэн хөгжүүлж байна. ЕХ-ноос батлан хэрэгжүүлж буй гол хууль, бодлогын баримт бичгүүд

нь ногоон угаалтаас урьдчилан сэргийлэх, үүрэг гүйцэтгэдэг. Үүнд дараах баримт тогтвортой санхүүжилтийг дэмжихэд чухал бичгүүдийг дурдаж болно (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Европын холбооноос баталсан гол баримт бичгүүд

Эрх зүйн акт	Тайлбар
Тогтвортой санхүүжилтийн ил тод байдлын журам – <i>Sustainable Finance Disclosure Regulation (EU) 2019/2088</i>	Тус журам нь санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагуудыг тогтвортой байдал, санхүүжилтийн мэдээллийг ил тод, үнэн зөв тайлагнах үүргийг тодорхойлсон.
Европын Холбооны ногоон таксономи – <i>EU Taxonomy Regulation (EU) 2020/852</i>	Тогтвортой эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлох нэгдсэн ангиллын систем (таксономи) бий болгож, хөрөнгө оруулалт болон бизнесийн үйл ажиллагаа нь тухайн ангилалд нийцэж буй эсэхийг шалгах шалгуур үзүүлэлтийг тогтоосон.
Компанийн тогтвортой байдлын тайлагналын удирдамж – <i>Corporate Sustainability Reporting Directive 2022/2464</i>	Тус удирдамжид зааснаар томоохон хувьцаат болон групп компаниуд жил бүр тогтвортой байдлын тайлан гаргах, стандартын дагуу ил тод, шалгаж болохуйц байдлаар мэдээлэх үүрэгтэй. Компаниудын тогтвортой байдлын талаарх мэдээллийг үнэн зөв, харьцуулж болохуйц байхаар зохицуулсан нь ногоон угаалтаас сэргийлэх ач холбогдолтой.
Ногоон зар сурталчилгааны тухай удирдамж – <i>Green Claims Directive, Proposal 2023/0166</i>	Энэхүү удирдамжийн дагуу “Эко”, “ногоон”, “байгальд ээлтэй”, “CO ₂ -гүй” гэх мэт байгаль орчинд ээлтэй гэх агуулгатай сурталчилгааны мэдэгдэл нь шинжлэх ухааны үндэслэлтэй, хөндлөнгийн нотолгоо болон нээлттэй тайлагналд тулгуурласан байх шаардлагатай. Энэхүү шаардлага нь бүх салбарын байгууллагуудын хэрэглэгчдэд зориулсан ногоон мэдэгдэл, сурталчилгаа, шошго (жишээ нь санхүүгийн салбарын аливаа бүтээгдэхүүн, хувцас, гоо сайхан, авто машин, аялал жуулчлал гэх мэт)–д хамаарна.
Европын ногоон бондын стандарт – <i>European green bond standard 2023/2631</i>	Уг журам нь ногоон болон тогтвортой байдлын чиглэлийн бондыг гаргах, зах зээлд нэвтрүүлэх, сурталчлах үйл явцыг зохицуулахын зэрэгцээ эдгээр бондтой холбоотой мэдээллийн ил тод байдал, гуравдагч этгээдээр баталгаажуулах болон зохицуулагч байгууллагын хяналт зэрэг харилцааг зохицуулдаг.

Олон улсын судлаачид ЕХ–ны “Ногоон удирдамжийг Европын Парламент 2023 оны зар сурталчилгааны тухай удирдамж” нь 03 дугаар сарын 22–ны өдөр баталсан бөгөөд ногоон угаалтыг хязгаарлах чиглэлээр авсан байгууллагуудаас хэрэглэгчдэд хүргэж хамгийн том алхмуудын нэг гэж үздэг. Уг буй мэдэгдэл, мэдээлэлд шинжлэх ухаанд

суурилсан, нотолгоотой, гуравдагч этгээдээр баталгаажуулсан, тодорхой, хэмжигдэхүйц байх шаардлага тавьж байгаагаараа бүсийн хэмжээнд ногоон угаалтыг зохицуулах анхны цогц баримт бичиг болсон. Удирдамжийн хүрээнд Европын комисс болон гишүүн улсууд нь шошго, баталгаажуулалтын төвлөрсөн бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэх, шаардлагатай хууль эрх зүйн орчин, дэд бүтэц, аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсруулах үүрэг хүлээх бөгөөд баримт бичгийн хэрэгжилтэд гишүүн орнуудын үндэсний хяналтын байгууллагууд хяналт тавьдаг.

Тус удирдамжийн дагуу байгууллагуудаас хэрэглэгчдэд хүргэж буй байгаль орчинд ээлтэй гэх мэдээлэл, зар сурталчилгаанд дараах үндсэн шаардлага тавьдаг:

- Байгаль орчны мэдэгдэл бүр нь амьдралын мөчлөгийн үнэлгээ (Life Cycle Assessment)–нд суурилсан тооцоолол, дүн шинжилгээгээр баталгаажсан байх;
- бүтээгдэхүүнийг гуравдагч этгээдээр хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэсэн байх;
- мэдэгдэлд ашигласан хэллэг нь тодорхой, хэмжигдэхүйц, мөн хугацаа болон хамрах хүрээ нь ойлгомжтой байхаас гадна төөрөгдүүлэх байдлаар илэрхийлэгдээгүй байх;
- ижил төрлийн бүтээгдэхүүнтэй харьцуулсан мэдэгдэл хийсэн тохиолдолд уг харьцуулалт нь нэгэн ижил шалгуур, ижил нөхцөлд суурилсан байх;
- “Ногоон”, “эко”, “байгальд ээлтэй”,

“байгалийн гаралтай” гэх мэт ойлголтыг илэрхийлсэн шошгыг ашиглах тохиолдолд энэ нь албан ёсны, итгэмжлэгдсэн олон улсын стандартын хүрээнд батлагдсан байх;

- хэрэв тухайн бүтээгдэхүүн зөвхөн хэсэгчлэн байгальд ээлтэй бол үүнийг заавал тодруулан тайлбарлаж, нийт бүтээгдэхүүнийг бүхэлд нь тогтвортой, байгальд ээлтэй гэж ойлгуулах сурталчилгаанаас татгалзах;
- байгаль орчинд ээлтэй гэх мэдэгдэл хүргэж буй этгээд нь зөвхөн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэгч байх;
- “Ногоон”, “эко”, “байгальд ээлтэй”, “байгалийн гаралтай” гэх ойлголтыг нотолгоо болон хэмжигдэхүйц үндэслэлгүйгээр ашиглахыг хориглоно.

Түүнчлэн, хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн, нотолгоогүй эсхүл баталгаажгаагүй байгаль орчны мэдэгдэл, зар сурталчилгаа гаргасан тохиолдолд тухайн этгээдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлээс татах, үндэслэлгүй болон худал мэдэгдлийг олон нийтэд залруулгаар хүргүүлэх, мөнгөн торгууль оногдуулах, “ногоон” шошго хэрэглэх эрхийг түр буюу бүрэн хэмжээгээр хязгаарлах, давтан зөрчил гаргасан тохиолдолд тухайн этгээдийн үйл ажиллагааны эрхийг хасах, сурталчилгааг тодорхой хугацаанд хязгаарлах, эсхүл хориглох зэрэг хариуцлагын арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Эдгээр арга хэмжээ нь зөвхөн хэрэглэгчийн

эрх ашгийг хамгаалахад чиглэгдэхээс гадна, зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжих, тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн итгэлцэл бүхий бизнесийн орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

4.2.2. Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

Сүүлийн жилүүдэд АНУ ногоон хөрөнгө оруулалтын итгэлцлийг нэмэгдүүлэх, ногоон угаалтаас сэргийлэх чиглэлд анхаарал ихээр хандуулж хэд хэдэн чухал зохицуулалтын баримт бичиг баталсан (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Америкийн Нэгдсэн Улсын баталсан гол баримт бичгүүд

Эрх зүйн акт	FTC act	SEC-ын нэрийн дүрэм	Ногоон хөтөч
Эрх зүйн акт	Federal Trade Commission Act 1938	SEC Rule 35d-1 (“Naming Rule”)	Green Guide удирдамж
Зорилго	Хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн, хуурамч сурталчилгаанаас хамгаалах	Санхүүгийн бүтээгдэхүүний нэр, маркетингийн мэдээлэл бодитой, үнэн зөв байдлыг хангах	Хэрэглэгчийг төөрөгдүүлэх, худал, эсвэл батлагдаагүй “ногоон” сурталчилгаанаас хамгаалах, компаниудад үнэн зөв “ногоон” мэдэгдэл хийхэд туслах, зах зээл дээр шударга өрсөлдөөн бий болгох ³⁴
Хамрах хүрээ	Бүх төрлийн худалдаа, сурталчилгаа	Хөрөнгө оруулалтын сангууд, ETF хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүд гэх мэт	Сурталчилгаа, шошго, маркетинг
Хяналтын байгууллага	Federal Trade Commission (FTC)	Securities and Exchange Commission (SEC)	FTC
Шийтгэл	Торгууль, зар сурталчилгааг зогсоох	Сангийн нэрийг өөрчлүүлэх, SEC шалгалт	Зөрчлийн хэрэг үүсгэх боломжтой
“Ногоон” нэр томъёоны хяналт	Ерөнхий тайлбаргүй “ногоон” сурталчилгааг хориглодог	ESG нэртэй сангууд, бүтээгдэхүүн тодорхой үнэлгээ, бодлого, стратегитай байх ёстой	“Тогтвортой”, “еко-нөхөрсөг” гэх мэт нэр томъёог хэрхэн хэрэглэхийг заасан.
Тайлбар	Компани “100% байгальд ээлтэй” гэж сурталчлаад, нотолгоогүй бол хууль зөрчсөнд тооцно	“Green Energy Fund” нэртэй бол дор хаяж 80 хувь нь цэвэр эрчим хүч рүү хөрөнгө оруулах ёстой	“Ногоон бонд” гэж нэрлэхийн тулд тодорхой экологийн шалгуурыг хангах шаардлагатай

³⁴ <https://www.ftc.gov/business-guidance/advertising-marketing/environmental-marketing>

АНУ-ын хувьд Холбооны худалдааны комисс (Federal Trade Commission, FTC)–аас 1992 онд гаргасан “Green Guides”³⁵ (Environmentally Friendly Product Marketing Guidelines) гэж нэрлэгддэг удирдамж бөгөөд 2012 онд шинэчилсэн.

Уг удирдамж нь эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичиг биш боловч, FTC нь Section 5 of the FTC Act (15 U.S.C. § 45) – хэрэглэгчдийг төөрөгдүүлэх, шударга бус үйлдлүүдийг хориглодог (*unfair or deceptive acts or practices*)³⁶ заалтыг удирдлага болгон мөрдөн шалгадаг ба хэрэв зөрчвөл арга хэмжээ авна³⁷. Тухайлбал:

- Иргэний хэрэг үүсгэж, торгууль ногдуулах;
- худалдааны хориг тавих;
- худал мэдэгдлийг зогсоох буюу засварлах шаардлага тавих;
- хэрэглэгчдэд учирсан хохирлыг барагдуулах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах;
- урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зах зээлд шударга байдлыг хангах.

Green Guides–аас сурталчилгаанд тавигддаг шаардлага:

- Тодорхой, үнэнч, батлагдсан байх: Сурталчилгааны бичвэрүүдэд өгөгдсөн “ногоон” ашиг тус үнэн байх ёстой. Шинжлэх ухааны баримт, судалгаа, туршилт гэх мэт батлагдсан эх үүсвэртэй байх;
- Төрөлжилт: Ямар хэсэгт хэрэглэж

байгаа талаар тод заах, жишээ нь зөвхөн сав, эсвэл бүтээгдэхүүнд гэх мэт;

- Чанар ба мэдээллийг тод харуулах: Боломжит хязгаарууд, нөхцөлүүдийг хэрэглэгчдэд ойлгомжтой, харагдахуйц, тодорхой хэлбэрээр мэдээлэх;
- Нийтлэг зөвлөмжүүд: “recyclable”, “biodegradable”, “compostable”, “renewable”, “non-toxic” зэрэг өндөр түгээмэл хэрэглэгддэг нэр томъёо болон нэр томъёоны ард байгаа нөхцөлийг (жишээ нь ямар нөхцөлд “compostable” болох) зааж өгөх.

Экологийн мэдэгдэл, шошгод тавьдаг шаардлага:

- Ерөнхий “ногоон” мэдэгдэл – “Байгальд ээлтэй” гэх мэт ерөнхий нэр томъёолол нь хүмүүсийг төөрөгдүүлэх тул тухайн бүтээгдэхүүний талаар тодорхой тайлбар, нотолгоотой байх. Тухайлбал: Энэ бүтээгдэхүүн 100% дахин боловсруулсан хуванцраар хийгдсэн (This product is made with 100% recycled plastic) гэх нь зөвшөөрөгдөх ч, хэрэв энэ бүтээгдэхүүн байгальд ээлтэй (This product is eco-friendly) гэвэл хангалтгүй.
- Дахин боловсруулах боломжтой (Recyclable) – хэрэглэгчийн амьдрах бүс нутагт тухайн бүтээгдэхүүн эсхүл баглаа боодлыг дахин боловсруулах дэд бүтэц байрладаг байх, эсхүл

³⁵ <https://www.ftc.gov/news-events/topics/truth-advertising/green-guides>

³⁶ <https://www.ftc.gov/sites/default/files/attachments/press-releases/ftc-issues-revised-green-guides/greenguides.pdf>

³⁷ <https://www.ftc.gov/sites/default/files/attachments/press-releases/ftc-issues-revised-green-guides/greenguides.pdf>

цөөн хувь нь дахин боловсруулах боломжтой бол түүнийгээ тодорхой бичих. *Жишээ нь*, магадгүй танай бүс газарт дахин боловсруулагдахгүй байж болно (*may not be recyclable in your area*).

- Дахин боловсруулсан түүхийг эд ашигласан (Recycled content) – бүтээгдэхүүн доторх дахин боловсруулсан материалын хувь хэмжээг тодорхой илэрхийлэх. *Жишээ нь*: “Made with 30% recycled fiber”.
- Биологийн задралтай / бордоонд хувирдаг (Biodegradable / Compostable) – тухайн бүтээгдэхүүн тодорхой хугацаанд, байгаль орчны энгийн нөхцөлд, хоргүйгээр бүрэн задардаг болохыг нотлох. *Жишээ*: “Compostable where facilities exist” гэж нөхцөлийг заавал тэмдэглэх.
- Хортой бодис агуулаагүй (Non-toxic) Хэрэглэгчид “non-toxic” гэх тэмдэглэгээг хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд бүх талаараа аюулгүй гэж ойлгох хандлагатай байдаг тулуг тэмдэглэгээг хэрэглэхдээ утгыг нь хязгаарлаж, нөхцөлийг

тодорхой зааж өгөх шаардлагатай. *Жишээ нь*: хүүхдэд ойртуулахад аюулгүй гэх мэт.

- Нүүрстөрөгчийн ялгарал нөхсөн (Carbon offset) – мэдэгдэл баталгаажуулахын тулд бодит хэмжилт, тооцоо, баталгаажуулсан гэрчилгээ шаардлагатай.
- Сэргээгдэх эрчим хүч, сэргээгдэх материал (Renewable energy / Renewable materials) – Бүтээгдэхүүний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүч ашигласан тохиолдолд ямар төрлийн эрчим хүч ашигласныг тодорхой заах шаардлагатай. *Тухайлбал*, “Made with 100% wind energy” гэж бичих нь зөв бол, ерөнхийд нь “Made with renewable energy” гэж тэмдэглэх нь хангалтгүй.

4.2.3. Сингапур Улс

Сингапур Улс нь “ногоон угаалт”-ыг тусгай хуулиар шууд зохицуулаагүй ч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, сурталчилгааны код, санхүүгийн хяналтын хуулиудын хүрээнд хууль бус экологийн мэдэгдлүүдтэй тэмцэх болон түүнийг хязгаарлах зохицуулалтыг тусгасан байдаг (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Сингапур Улсад мөрдөгдөж буй гол баримт бичгүүд

Эрх зүйн акт	Тайлбар	Чиг үүрэг хариуцсан байгууллага
Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (Consumer Protection (Fair Trading) Act) CPFTA) (2003)	– Хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн, худал, хуурамч (түүний дотор “ногоон”) мэдэгдлээс хамгаалах – худалдааны байгууллагуудын буруу, ташаа, үл ойлгогдох мэдэгдлүүдийг хориглосон заалтуудтай	Өрсөлдөөн ба Хэрэглэгчийн Комисс (Competition and Consumer Commission of Singapore (CCCS))(CCCS)

Сурталчилгааны ёс зүйн дүрэм (Singapore Code of Advertising Practice (SCAP))	– “Ногоон” мэдэгдлийг сурталчилгаанд үнэн, нотлох баримттайгаар ашиглах – хэтэрхий тууширсан хэлбэртэй экологийн амлалт, нотолгоогүй мэдэгдлүүдийг хориглох заалтуудтай.	Сурталчилгааны Стандартын Зөвлөл (Advertising Standards Authority of Singapore (ASAS))
Санхүүгийн байгууллагын байгаль орчин, нмйгэм засаглал (БОНЗ) –ын удирдамж MAS CIRCULAR NO. CFC 02/2022	ESG/“ногоон” нэртэй сангийн нэршил, стратеги, хөрөнгө оруулалтын ил тод байдалд шалгуур тогтоох	Сингапурын мөнгөний бодлогын газар (Monetary Authority of Singapore (MAS))
Сингапур–Азийн Таксономи	Тогтвортой, шилжилтийн үйл ажиллагааг тодорхойлох, ангилах стандарт тогтоох	AS
Ногоон мэдэгдэл хийх зөвлөмжүүд (Guidelines on Environmental Claims)	Байгаль орчны талаарх мэдэгдлийг бодит, баталгаатай, ойлгомжтой байдлаар гаргах	CCCS, ASAS Consumers Association of Singapore (CASE)
Тогтвортой ногоон шошгын схем (Sustainable Green Label Scheme (SGLS))	Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээнд таних тэмдэг (eco-label) олгож, хэрэглэгчдийг зөв сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх	Сингапурын Байгаль Орчны Зөвлөл (Singapore Environment Council (SEC)) ³⁸

Сингапур Улс нь финтек компаниудад зориулсан «Sandbox» хөтөлбөр хэрэгжүүлдэг. Уг хөтөлбөр нь ногоон финтек шийдлүүдийг хязгаарлагдмал орчинд турших боломж олгодог ба энэ нь санхүүгийн салбарт инновацыг дэмжих, эрсдэлийг бууруулах зорилготой юм.

Дээр дурдсан зохицуулалтын бичиг баримтаас Ногоон шошгын схемийг онцолж байна. Энэ баримт бичгийн шаардлага хангасан байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээнд Singapore Green Labelling Scheme (SGLS)–ын дагуу

баталгаажуулалт хийж тусгай гэрчилгээ олгож, “Ногоон шошго”–ыг хэрэглэх эрх өгдөг. Уг гэрчилгээ нь олон улсын ISO 14024 ecolabelling стандартыг баримталдаг ба хөндлөнгийн аудит, лабораторийн шинжилгээ, баримт бичгийн шалгалт дээр үндэслэнэ.

Үүнийг 1992 онд Сингапур Улсын Байгаль орчны яамнаас санаачлан эхлүүлсэн бөгөөд 1999 онд SEC–д шилжүүлсэн. Энэхүү схем нь бүтээгдэхүүний түүхий эдээс эхлэн үйлдвэрлэл, хэрэглээ, хаягдал болтол амьдралын мөчлөгийг (Life Cycle

³⁸ <https://www.sec.org.sg>

Assessment) үнэлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилготой³⁹.

SGLS нь хэрэглэгчид “ногоон” гэх сурталчилгаанд хууртахгүй, итгэмжлэгдсэн бүтээгдэхүүн сонгох боломжийг олгох бол компаниудад байгаль орчны хариуцлагаа харуулсан бүтээгдэхүүнүүдээр зах зээлд өрсөлдөх боломжийг хөшүүрэгдэж өгдөг.

Өнөөдрийн байдлаар SEC нь 830 компанийн 3,700 нэр төрлийн бүтээгдэхүүнийг 13,000 гаруй ногоон шошгын гэрчилгээгээр баталгаажуулсан байна.

SEC-ын сертификаттай бүтээгдэхүүнийг Малайз, Индонез, Хятад, АНУ зэрэг 50 гаруй оронд худалдах эрхтэй. Энэ нь оролцогч талуудад түүний найдвартай байдлын баталгаа нь юм. Сингапурын ногоон шошго авах өргөдөл нь дотоодын болон гадаадын компаниудад нээлттэй байдаг⁴⁰.

4.3.4. Монгол Улс

Монгол Улс бол байгалийн нөөц баялаг ихтэй тул байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр хэд хэдэн хууль, бодлогын баримт бичиг баталж мөрдөж байна. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)⁴¹;
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль (1910)⁴²;
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003)⁴³;
- “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020);
- Монгол Улсын Ногоон таксономи (2019)⁴⁴;
- Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг (2022)⁴⁵.

Мөн Монгол Улсын “Зар сурталчилгааны тухай” (2002) хууль нь арилжааны зорилгоор бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд түгээхтэй холбоотой харилцааг зохицуулдаг. Уг хуульд шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой заалтууд тусгагдсан. Түүнчлэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага нь сурталчилгааны мэдээллийн нотолгоо, тайлбар авах эрхтэй гэж заажээ.

Гэвч эдгээр баримт бичиг, эрх зүйн актад “ногоон бүтээгдэхүүн” эсвэл “ногоон

³⁹ <https://www.ecolabelindex.com/ecolabel/singapore-green-label-scheme>

⁴⁰ <https://globalecolabelling.net/organisation/singapore-green-labelling-scheme>

⁴¹ <https://legalinfo.mn/mn/detail/8935>

⁴² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=30>

⁴³ <https://legalinfo.mn/mn/detail/551>

⁴⁴ https://mof.gov.mn/files/uploads/article/1.1_%D0%9D%D0%BE%D0%B3%D0%BE%D0%BE%D0%BD_%D1%82%D0%B0%D0%BA%D1%81%D0%BE%D0%BD%D0%BE%D0%BC%D0%BC%D0%B8_compressed_%281%29_.pdf

⁴⁵ <https://www.frc.mn/resource/frc/Document/2023/03/01/y7zy4urk7ovu2m k3/%D0%A5%D0%B0%D0%BC%D1%82%D0%B0%D1%80%D1%81%D0%B0%D0%BD%20%D1%82%D1%83%D1%88%D0%B0%D0%B0%D0%BB%202022.03.29%20-%20%D0%A2%D0%BE%D0%A1%20%D0%97%D0%B0%D0%BC%D1%8B%D0%BD%20%D0%B7%D1%83%D1%80%D0%B0%D0%B3.pdf>

үйлчилгээ”-г тодорхойлох нарийн шалгуур, стандарт бүрэн тусгагдаагүй болно.

Санхүүгийн салбарын хувьд дараах байгууллагууд голлох үүрэгтэй ажиллаж байна.

1. Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо):

Тус холбоо нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарыг тогтвортой хөгжлийн зарчмуудад нийцүүлэх зорилготой, сайн дурын үндсэн дээр байгуулагдсан. ТоС Холбоо нь банкны тогтвортой санхүүжилтийн стандартыг боловсруулан хэрэгжүүлж, гишүүн банкнууд болон банк бус санхүүгийн байгууллагуудад ногоон зээл, төслийг үнэлэхэд тусалдаг.

ТоС Холбоо нь 2013 оноос хойш Монголын банк, санхүүгийн салбарт тогтвортой байдлын зарчмыг нэвтрүүлж, «Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр»-ийг амжилттай хэрэгжүүлж байна.

2. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ):

СТБЗ нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар 2007 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах, тогтолцооны эрсдэлийг илрүүлэх, бууруулах үйл ажиллагааг уялдуулах үндсэн чиг үүрэгтэй. СТБЗ нь Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо,

Хадгаламжийн даатгалын корпорацийн төлөөллөөс бүрддэг⁴⁶.

3. Монголбанк (Төв банк):

Монголбанк нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ногоон эдийн засгийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх гол үүрэгтэй. Монголбанк нь ногоон санхүүжилтийн таксономийн хэрэгжилтийг хангуулах ажлыг удирдан зохион байгуулж байна. Энэ нь ирээдүйд ногоон төсөл, бүтээгдэхүүнийг тодорхойлох нэгдсэн стандарттай болж, хуурамч «ногоон» бүтээгдэхүүнээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм. Монгол банк 2020 оноос арилжааны банкнуудаас ногоон зээлийн мэдээллийг улирал бүр авдаг болсон⁴⁷.

4. Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ):

СЗХ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн.

Тус байгууллага нь 2006 оноос эхлэн үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж зээлийн хоршооныг гэсэн 4 санхүүгийн салбар байсан бол нэмэлт өөрчлөлт болон шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомжид зааснаар тус байгууллагын зохицуулалтад өнөөдөр санхүүгийн болон мэргэжлийн үйлчилгээ

⁴⁶ <https://www.mongolbank.mn/mn/p/about-the-financial-stability-council>

⁴⁷ <https://www.barilga.mn/n/24338>

үзүүлэгч 11 салбарыг хамраад байна. Тус байгууллага нь өөрийн зохицуулалтын салбарт ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг

дэмжиж зохицуулалт, хяналт тавьж ажиллаж байна.⁴⁸ (Хүснэгт 5).

Хүснэгт 6. СЗХ-ны хэрэгжүүлсэн арга хэмжээ, хэрэгжилт

Үнэт цаасны зах зээл	ББСБ-ын зах зээл	Даатгалын зах зээл
2021 онд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д “Ногоон бонд” гаргах зохицуулалтыг тусгасан.	2022 онд “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг баталсан.	2022 онд “Даатгалын багц дүрэм”-д “Ногоон даатгал”-ыг тодорхойлж, даатгалын компаниуд энэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Түүнчлэн даатгалын компаниудын ногоон бондод хөрөнгө оруулах хөрөнгийн ангиллыг тусгасан.
2024 оны байдлаар		
<ul style="list-style-type: none"> - Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 1 болон 2 дугаар самбарын компаниуд тухайн тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ESG стратеги, арга хэмжээний талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд жил бүр ил тод байдлаар тайлагнах үүрэг хүлээсэн⁴⁹. - 2024 онд 45 сая ам.долларын үнийн дүн бүхий 2 ногоон бонд бүртгэгджээ. 	<ul style="list-style-type: none"> - Банк бус санхүүгийн байгууллагууд улирал бүр тогтмол ногоон зээлийн статистик мэдээлэл гаргадаг болсон. 2025 оны I улирлын байдлаар 8,607 зээлдэгчид олгосон ногоон зээлийн үлдэгдэл 111.7 тэрбум төгрөг байгаа нь тус салбарын нийт зээлийн үлдэгдлийн 1.8 хувийг эзэлж байна. - СЗХ нь 2030 он гэхэд банкнаас бусад санхүүгийн салбарын ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 5 хувьд хүргэх зорилтыг тавин ажиллаж байна. 	<ul style="list-style-type: none"> - Даатгалын компаниуд ESG тайлангаа сайн дураар тайлагнадаг болсон. - Бүртгэгдсэн ногоон даатгал: <ul style="list-style-type: none"> - “Тэнгэр” даатгал – Эрчим хүч хэмнэх гэрээний хариуцлагын даатгал; - “Миг” даатгал – Есо цахилгаан тээврийн хэрэгслийн даатгал.

⁴⁸ <https://www.frc.mn/#/list?id=2>

⁴⁹ <https://www.barilga.mn/n/24338>

Өнөөгийн байдлаар СЗХ нь ногоон гэх санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээнд тусгайлсан газар дээрх шалгалт хийгээгүй байна.

4.3.5. Улс орнуудын зохицуулалтын харьцуулалтын шинжилгээ

ЕХ, АНУ, Сингапур болон Монгол Улсад мөрдөж буй эрх зүйн актад ногоон угаалтын эсрэг тусгасан зохицуулалтын онцлогуудыг харьцуулан шинжлэхэд ЕХ нь ногоон угаалтаас сэргийлэх хамгийн цогц, хатуу зохицуулалттай бүс нутаг бөгөөд ил тод байдал, тогтвортой тайлагнал, ногоон зар сурталчилгааны баталгаажуулалт, таксономи, бондын стандарт гэх мэт нарийн системтэй эрх зүйн орчин бүрдүүлсэн.

АНУ бол хэрэглэгчийг хамгаалах, хөрөнгө оруулалтын зах зээлд итгэлцлийг хангах зорилгоор FTC болон SEC-ийн зохицуулалт (Green Guides, Naming Rule) хэрэгжиж, “ногоон” нэршил, сурталчилгааг үнэн зөв, нотолгоотой байлгахыг шаарддаг.

Сингапур Улс харин тусгай “ногоон угаалт” –ын хуульгүй ч хэрэглэгчийн эрхийг хамгаалах

хууль, сурталчилгааны ёс зүйн дүрэм, санхүүгийн ил тод байдлын удирдамж, ногоон шошгын схем зэрэг олон талт зохицуулалтаар дамжуулан ногоон угаалтыг хязгаарлаж, баталгаажуулсан “эко шошго” –ны тогтолцоог хөгжүүлсэн.

Монгол Улсын хувьд “Ногоон угаалт” гэх нэр томьёо Монголын санхүүгийн салбарт шинэлэг бөгөөд цаашдын бодлогод анхаарах чиглэлээ болгох шаардлагатай байна. Хэдийгээр Тогтвортой санхүүжилтийн бодлого, ногоон таксономи, замын зураглал, зар сурталчилгаа болон хэрэглэгчийн эрхийн хуульд буруу, төөрөгдүүлсэн мэдээллийг хориглосон боловч ногоон угаалтад чиглэсэн Тухайлбал ESG үнэлгээ, түүний харьцуулалт, үнэн тайлагнасан эсэхэд дүгнэлт өгөх, шалгах, хөндлөнгийн аудит хийх төдийгүй санхүүгийн бүтээгдэхүүнд “ESG”, “ногоон”, “тогтвортой” гэх зэрэг тэмдэглэгээ, нэр томьёог ашиглах, түүнтэй холбоотой сурталчилгааны зохицуулалт, түүний бодит нөлөөллийг хянан баталгаажуулах механизм, хяналт шалгалтын тогтолцоо бүрдээгүй байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

“Санхүүгийн салбар дахь ногоон угаалт” судалгаа нь дэлхий дахинд «ногоон угаалт» буюу компанийн хуурамч, төөрөгдүүлсэн «ногоон» сурталчилгаа хэрхэн ихэссэн, ямар хэлбэрээр илэрдэг, түүний үр дагаврыг харууллаа. Олон улсын жишээнүүдээс харахад, Олон улсын хэмжээнд Тайлагналын олон улсын санаачилга GRI, Тогтвортой тайлагналын стандарт зөвлөл SASB, Байгаль орчны гүйцэтгэлийг хэмжих, тайлагнах, баталгаажуулахтай холбоотой ISO 14030 зэрэг стандартууд мөрдөгдөж байна. Мөн сонгон судалсан Европын холбоо (ЕХ), АНУ, Сингапур зэрэг улсууд ногоон угаалттай тэмцэхэд чиглэсэн хууль эрх зүйн тодорхой зохицуулалт, стандартыг хэрэгжүүлж байгаа төдийгүй хяналтын тогтолцоо бүрдүүлэн ажиллаж байна. Тухайлбал, ЕХ-ны Таксономийн журам, Сингапур Улс нь Сурталчилгааны ёс зүйн дүрэм, АНУ-ын SEC болон FTC-ийн удирдамжууд нь компаниудын «ногоон» гэх мэдэгдлийг бодитой болгоход хүчтэй нөлөөлж байна.

Харин Монгол Улсад ногоон санхүүжилтийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа ч, ногоон угаалттай шууд тэмцэх, хяналт тавих тодорхой эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

Сонгон судалсан улс орнуудад төрийн байгууллагууд (SEC, FTC, CCCS) ногоон угаалтад хатуу хяналт тавьж, хариуцлага тооцдог бол Монголд бол ногоон зээлийн мэдээ, байгаль орчин нийгэм засаглалын тайлан авах хүрээнд гүйцэтгэгдэж байна.

Олон улсын компаниуд тогтвортой байдлын тайлангаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу бэлтгэдэг бол манай улсад энэ нь хараахан тогтож хэвшил болоогүй төдийгүй ESG мэдээллийн үнэн зөв байдал, хөндлөнгийн хяналт, олон нийтийн ойлголт хангалтгүй хэвээр байна.

Иймээс дараах бодлогын зөвлөмжүүдийг дэвшүүлж байна. Үүнд:

Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох:

Монгол Улсын нөхцөлд тохирсон «ногоон» эдийн засгийн үйл ажиллагааны нэгдсэн жагсаалт, шалгуурыг тогтоож, журамлах эсхүл хуульчлах.

Зохицуулалтын нарийн шаардлага тогтоох:

Ногоон бонд, ногоон зээл зэрэг санхүүгийн бүтээгдэхүүнүүдэд тавигдах шаардлагуудыг баталгаажуулах. Ялангуяа, эдгээр бүтээгдэхүүнээс олсон орлогыг хэрхэн, юунд зарцуулж буй талаар тайлагнал, ил тод байдлыг баталгаажуулах.

Хяналтын механизмыг сайжруулах:

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) эсхүл Монголбанк зэрэг байгууллагуудад ногоон угаалттай тэмцэх, хяналт тавих чиг үүргийг өгөх. Хуурамч мэдээлэл түгээсэн компаниудад торгууль, хариуцлага хүлээлгэх механизмыг бий болгох.

Үндэслэлтэй баримт шаардах:

«Байгальд ээлтэй», «эко», «ногоон» гэх мэдэгдэл хийсэн компаниудаас сертификат, аудит хийлгэсэн тайлан, судалгаа зэрэг

бодит нотолгоог шаарддаг тогтолцоог бий болгох.

Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх:

Хөрөнгө оруулагчид, хэрэглэгчид, компанийн менежерүүдэд ногоон угаалтын талаар мэдлэг олгох сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах.

Тайлагналын стандартыг нэвтрүүлэх:

Компаниудыг байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) нөлөөллийн талаарх

тайланг тогтмол, нэгдсэн стандарт (жишээ нь, GRI, SASB)-ын дагуу олон нийтэд ил тод тайлагнаж байхыг шаардах.

Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх:

ЕХ-ны «Ногоон Таксономи» болон АНУ-ын SEC-ийн дүрэм, удирдамж болон олон улсын туршлагуудыг Монголын нөхцөл байдалд тохируулан судлах, нэвтрүүлэх. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, техникийн туслалцаа авах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- “Biggest Financial Players Back Net Zero.” United Nations, <https://www.un.org/en/climatechange/biggest-financial-players-back-net-zero>.
- “BNY Mellon Charged for ESG Quality Review Misstatements.” Peters & Peters, <https://www.petersandpeters.com/case/bny-mellon-charged-for-esg-quality-review-misstatements>.
- Climate change and European Aquatic Resources (CERES) & United Nations Environment Programme (UNEP). (1997). Global Reporting Initiative (GRI) Standards. Amsterdam: GRI Secretariat. , <https://www.globalreporting.org/>.
- “Equator Principles Action Report 2023.” Equator Principles, p. 3.
- “Green Claims.” European Commission, 2012 https://environment.ec.europa.eu/topics/circular-economy/green-claims_en.
- “Green Guides.” Federal Trade Commission (FTC), <https://www.ftc.gov/news-events/topics/truth-advertising/green-guides>.
- “Greenwashing Incidents up 70% Globally in 2023.” Trade Finance Global, <https://www.tradefinanceglobal.com/posts/report-greenwashing-incidents-up-70-globally-2023/>.
- Securities and Exchange Commission. (2022). Rule 35d-1 “Naming Rule” — Investment Company Names. Washington D.C.: SEC
- “ISO – International Organization for Standardization.” ISO, <https://www.iso.org/home.html>.
- “SASB Standards.” IFRS Foundation, <https://sasb.ifrs.org/>.
- “Save Shah Alam Community Forest.” New Straits Times, <https://shahalamforest.org/wp/residents-nature-lovers-and-ngos-unite-in-last-ditch-battle-to-save-shah-alam-community-forest-from-imminent-destruction-new-straits-times-jun-2024/>.
- “Singapore Green Labelling Scheme.” Global Ecolabelling Network, <https://globalecolabelling.net/organisation/singapore-green-labelling-scheme>.
- “Sustainability Certifications.” Ceres Cert, <https://www.ceres-cert.de/en/home>.
- “What Are the Principles for Responsible Investment?” UN PRI, <https://www.unpri.org/about-us/what-are-the-principles-for-responsible-investment>.
- RepRisk. (2023). Greenwashing Risk in the Financial Sector: 2023 Report. Zurich: RepRisk AG.
- “Монголын тогтвортой санхүүгийн холбоо” 2022. https://www.mongolbank.mn/file/files/documents/press_conference/20220812_01.pdf. Accessed

- Gellweiler, S., and P. Higson. The SAGE International Encyclopedia of Travel and Tourism. Vols. 1–4, SAGE Publications, 2017, pp. 544–546.
- Greenwashing: 3 Case Studies. Sustainability Unlocked, <https://sustainabilityunlocked.com/videos/greenwashing-3-3-case-studies>.
- Intergovernmental Panel on Climate Change (IPCC). Climate Change 2023: Synthesis Report. IPCC, 2023, p. 1553, https://www.ipcc.ch/report/ar6/syr/downloads/report/IPCC_AR6_SYR_SPM.pdf.
- U.S. Securities and Exchange Commission. “SEC Charges BNY Mellon Investment Adviser for Misstatements and Omissions Concerning ESG Considerations.” SEC.gov, Press Release No. 2022–86, <https://www.sec.gov/newsroom/press-releases/2022-86>. Accessed 10 June 2025.
- OECD. (2022). Green claims and market transparency. OECD Publishing
- Francesca, A. (2025). Greenwashing in finance. *Journal of Sustainable Business*, 12(3), 45–59.

